

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хагаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг буурцуулах, арилгах, урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөргө үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь элсний ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөн нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах зүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Бэлдэвжих” ХХК нь мөрдөж ажиллана.

“Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхийл сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдснөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ боловсруулах ара аргачлал:

Тус төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төслийн БОМТ-нд 2024 онд нийт 1,3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

1. Төслийн товч танилцуулга


Төслийн нэр: “Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төсөл

Төслийн зорилго: Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бетоны үйлдвэр, баяжуулах үйлдвэрүүдэд бетоны нэмэлт химийн бодисын бүтээгдэхүүний түүхий эд, баяжуулах үйлдвэрийн урвалжаар хангах үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Төслийн явц, байршил: “Бэлдэвжих” ХХК нь бетон зуурмагийн нэмэлт бодисуудыг ОХУ-ын Новосибирскээс импортлон оруулж ирж борлуулах төслийг эхлүүлж байгаа бөгөөд худалдагч талтай нэр бүхий 10 төрлийн бодисын худалдааны гэрээг байгуулсан, тээвэр ложистикийн компанитай аман хэлэлцээр хийсэн, агуулахтай түрээсийн гэрээ хийсэн байдалтай байна. Түрээслэж буй агуулах нь “Эм Эм Си Эйч” ХХК-ийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, 384-р гарам 41 гудамжны 07 тоот 3000 мкв газартай 198 мкв агуулахын зориулалттай барилга байна.

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээллэл

1	Аж ахуйн нэгжийн нэр	“Бэлдэвжих” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011457149	
3	Регистрийн дугаар	5800587	
4	Төслийн нэр	Химийн бодис хадгалах, худалдаалах, импортлох төсөл	
5	Төслийн байршил	Аймаг	Улаанбаатар хот
6		Сум/	Сонгинохайрхан дүүрэг
7	Захирлын мэдээлэл	Нэр	М. Лхавгасүрэн
8		Утас	91055595



Зураг №1. Төслийн талбайн байршилын зураг

Хүснэгт №2. Газрын координат цэг

№	Уртраг	Өргөрөг	Урт	Цэгүүд
---	--------	---------	-----	--------

1	5304964.60	622220.51	31.20	1-2
2	5304941.28	622199.78	19.98	2-3
3	5304595.83	622186.08	30.04	3-4
4	5304977.74	622206.63	32.00	4-5
5	5305001.08	622228.53	33.83	5-6
6	5305025.76	622251.67	35.38	6-7
7	5305051.57	622275.88	37.71	7-8
8	5305079.08	622313.88	15.37	8-9
9	5305068.69	622313.02	37.81	9-10
10	5305040.43	622287.90	35.69	10-11
11	5305013.76	622264.19	33.58	11-12
12	5304988.66	622241.89	32.19	12-1

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт №3. Ерөнхий танилцуулгын мэдээлэл

1	Төслийн нэр	Бетон зуурмагийн нэмэлт бэхжүүлэгч импортлох, ханган нийлүүлэх, худалдан борлуулах төсөл
2	Төслийн үндэслэл	Монгол улсын барилгын салбар жилээс жилд тэлэн олон мянган орон сууц, өндөр барилгуудыг барьж байгаа билээ. Барилгын чанарт тавигдах шаардлага стандарт нэмэгдэж байгаагаас үүдэн барилгын үндсэн түүхий эд болох бетон зуурмагийн чанарыг сайжруулах ажил ихээхэн чухал болж байна.
3	Төслийн зорилтууд	1. Байгал орчинд хор нөлөөгүй, чанарын спандартад нийцсэн аюулгүй нэмэлт бодис импортлох 2. Барилгын материалын мэргэшсэн чадварлаг боловсон хүчнээр багаа бүрдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх 3. Бетон зуурмагийн нэмэлтийн үнийг өрсөлдөгч байгууллагуудаас хямд тогтоож барилгын материалын үнийг бодитой байлгах, найрсаг түргэн шуурхай ажиллах
4	Хүлээгдэж буй үр дүн	Байгаль орчинд ээлтэй, стандартад нийцсэн чанартай бүтээгдэхүүнийг зах зээлд хямд үнээр нийлүүлнэ. Ингэснээр барилгын салбарын үнийн хөөсрөлт багасч өрсөлдөөн бий болон ард иргэдэд сайнаар нөлөөлнө. 6-10 хүнийг ажлын байраар хангана. Энэхүү төсөл нь барилгын материалын дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, нийгмийн хувьд үр нөлөөтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байх болно.
5	Төсөл хэрэгжих байршил	Улаанбаатар хот, СХД, 32-р хороо, 384-р гарам 41 гудамжны 07 тоот.

Төслийн хүчин чадал: Химийн бодисын агуулахын ашигтай талбай 198 м², төслийн хүрээнд нийт 10 нэр төрлийн химийн бодисыг импортлоно.

Химийн бодисыг сард 1 удаа татан авалт хийх ба нэг удаагийн татан авалт нь 20 тонн бодис хадгална. Төслийн хүрээнд агуулахын хүчин чадал 20-40тн-оос хэтрэхгүй. Жилийн татан авалтын хэмжээ 100тн байна.

Нийт импортоор орж ирэх бодисны 25-35 хувийг худалдан авагчид шууд хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна.

Бүтээгдэхүүдийн тодорхойлолт: “Бетон болон барилгын уусмалын нэмэгдэлд ашиглагдах бодисууд. “Ерөнхий техникийн нөхцөл” шаардлагад нийцсэн. ОХУ-ын ТУ 20.59.59-001-16918243-2018 шаардлагыг хангасан. Илэгдлийг үүсгэгч бодис агуулаагүй.

ДЭД БҮТЭЦ

Зам харилцаа: Агуулахын зориулалттай газар нь засмал замтай ойр, 365м явж төв замтай холбогдоно.



Зураг №2. Төслийн талбайн замын зураг

Цахилгаан хангамж: Төвийн нэгдсэн сүлжээнд холбогдсон

Харилцаа холбоо: Үүрэн холбооны бүх сүлжээнд холбогдсон учир холбооны нэмэлт тоног төхөөрөмж шаардлагагүй.

Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал: Хөдөлмөр, хамгаалал аюулгүй ажиллагааны журамтай байх, журмын дагуу үйл ажиллагаа явуулах

Цахилгаан хангамж: Төвийн нэгдсэн сүлжээнд холбогдсон.

Халаалт: Цахилгаанаар шийдсэн.

Харилцаа холбоо: Зарим үүрэн телефон утас барьдаг учир холбооны нэмэлт тоног төхөөрөмж шаардлагагүй.

Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал: Хөдөлмөр, хамгаалал аюулгүй ажиллагааны журамтай байх, журмын дагуу үйл ажиллагаа явуулах

Галын аюулгүй байдал: Галын дохиололтой, гал унтраах хэрэгслүүдээр бүрэн тоноглогдсон.

/Галын дүгнэлт тайланд хавсаргасан/

IV.4. Хог, хаягдал

Төслөөс гарах хог хаягдал: Төслийн хүрээнд энгийн хатуу хог хаягдал болон аюултай хатуу хог хаягдал гэсэн 2 төрлийн хаягдал гарна. Энгийн хог хаягдал нь хатуу шингэн гэсэн үндсэн 2 төлөв байдлаар гарна.

Энгийн хог хаягдал: Химийн бодис хадгалах агуулахад нярав, ачигч-2, жолооч, манаач гэсэн 5 орон тоо ажиллана гэж төлөвлөсөн. Ажилчдаас гарах хог хаягдал буюу ахуйн хатуу хог хаягдлын тооцоог хийв. Хоногт нэг хүнээс 0.5 кг хатуу хог хаягдал гарна гэж тооцвол ахуйн хэрэглээнээс гарах хатуу хог хаягдлын хэмжээ:

Хүснэгт №4. Хатуу хог хаягдлын тооцоо

Хоногт /кг/	Сард /кг/	Жилд -7 сар /кг/
0.5	55	385

Төсөл хэрэгжих хугацаанд агуулахын байранд ажилчид байнгын байрлахгүй. Тээвэрлэлт, нийлүүлэлт, буулгалт хийх тухай бүртээ ирж үйл ажиллагаагаа явуулна. Гэсэн хэдий ч төсөл хэрэгжүүлэх талбайд химийн бодисын агуулах нь барилга байгууламж, гадаад орчны өнгө үзэмжийг сайжруулах, хог хаягдал хадгалах, байгаль орчинд халгүй байлгах ажлын хүрээнд “Ахуйн хог хаягдлын цэг”-ийг тусгайлан тохижуулах шаардлагатай байна.

Ажилчдаас гарах ахуйн хатуу хог хаягдлыг: Сонгинохайран дүүргийн ТҮК-тай байгуулсан “Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ”-ний дагуу хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээний дагуу ачин зайлуулахаар төлөвлөсөн. /Гэрээг тайланд хавсаргав/.

“Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төсөл нь химийн бодис материал ашиглах, үйлдвэрлэх төсөл биш учраас хаягдал бага гарах хэдий ч дараах тохиолдлуудад хатуу болон шингэн хог, хаягдал зайлшгүй үүснэ. Үүнд:

- ✓ Хадгалах хугацаа нь дууссан хатуу болон шингэн бодис,
- ✓ Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
- ✓ Ариун цэврийн өрөөний хатуу ба шингэн гэх мэтийн хаягдлууд үүснэ.
- ✓ Санамсар, болгоомжгүйн улмаас асарч алдагдсан хүчтэй хүчил, шүлтүүдийг саармагжулсан шингэн хаягдал.
- ✓ Иймд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан зааварчилгааны дагуу хог, хаягдлын асуудлыг шийдвэрлэнэ.

IV.4.1. Шингэн хаягдал буюу ахуйн бохир ус

Хүснэгт №5. Шингэн хаягдал буюу бохир усны тооцоо

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Ажиллах өдөр	Хаягдлын норм л/хон	Сард ,л	Жилд ашиглах ус, м ³
						250 хоног/
1	Ажилтан	11	250	0.2	48.4	12.1

IV.4.2. Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал

Жилд 10 төрлийн 100 тн бодис борлуулах ба ашиглаж дууссан бодисын сав баглаа боодлыг “Элемент” ХХК мэргэжлийн байгууллагад шилжүүлэн байгаль орчинд ээлтэй хэлбэрээр устгуулна.

Хүснэгт №6. Химийн бодисын сав баглаа, боодлын хаягдал, ширхэгээр

№	Бодисын нэр	Савлагааны төрөл	Нэг бүрийн сав баглаа	Импортлох, тн	Аюултай хог хаягдал, ш
1	Суперпластификатор FLUX F5	Хуванцар	1тн	20	20
2	ADDITIVA20	Хуванцар	1тн	5	5
3	POLISINTONOL 101	Хуванцар	1тн	5	5
4	POLISINTONOL 201	Хуванцар	1тн	5	5
5	POLISINTONOL UF11	Хуванцар	1тн	10	10
6	Flux F5 SLOW 3	Хуванцар	1тн	10	10
7	FLUX11	Хуванцар	1тн	10	10

8	POLIFROM P5	Хуванцар	1тн	10	10
9	Solitard S1	Хуванцар	1тн	20	20
10	POLIFROM PM	Хуванцар	1тн	5	5
Нийт			10 тн	100 тн	100 ш

Хатуу хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь эх үүсвэрийг хязгаарлах, хаягдлыг тусгайлсан горимын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хэлбэрээр цуглуулах, ангилан хадгалах, хог хаягдлыг богино хугацаанд зайлуулах зэрэг юм

Агуулахаас гарах хог хаягдлыг шинж чанараар нь Монгол улсын “Хог хаягдлын тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралтад “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл”-д зааснаар эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлээр нь ангиллаа.

IV.4.3. Аюултай хог хаягдал буюу химийн бодисын сав баглаа боодол

Төслийн хүрээнд импортлон хадгалан, худалдаалах бодисууд нь дараах савлагаатай байна. Химийн бодисоо ОХУ-аас нийлүүлэлт хийхээр төлөвлөж байгаа. Химийн бодисын борлуулалтаас технологийн 3 төрлийн хатуу хог хаягдал гарна. Үүнд:

- ✓ Химийн бодисын сав баглаа боодол /мяндсан буюу поливинил материалтай шуудай, хуванцар савнууд
- ✓ Химийн бодисын хаягдал /хугацаа дууссах химийн бодис, асгарсан, бохирдсон үлдэгдэл
- ✓ Химийн бодисоор бохирдсон материал /бодисоор бохирдсон хувцас хэрэгсэл, арчдас материал, шингээгч материал

Зөвлөмж: Цаашдын үйл ажиллагаанд хатуу хог хаягдлын цэгийг салхины зонхилох зүгийн доор төлөвлөж ахуйн хог хаягдал салхиар тарж орчинг бохирдуулахгүй байхаар битүүмжлэлтэй хогийн савыг байрлуулах зүйтэй юм. Мөн ахуйн хогийг ангилан ялгаж дахин боловсруулагдах хог хаягдлыг тусад нь хадгалж эдийн засгийн эргэлтэд оруулах хэрэгтэй.

IV.5. Усан хангамж

Төсөл хэрэгжүүлэгч нь УСУГ-тай зөөврийн усны гэрээ байгуулсан хуулийн этгээд болох “Мастертийм” ХХК-тай байгуулсан гэрээгээр усан хангамжаа шийдвэрлэсэн.

Төслийн хүрээнд нийт 11 хүн ажиллах ба унд ахуйн хэрэгцээнд хоногт 1.65 м³, нийт хугацаанд 412.5 м³ ус ашиглана.

Хүснэгт №7. Унд ахуйн усны хэрэглээ

Ажиллах хугацаа	Ажилчдын тоо	Ажиллах хугацаа	Нэг хүний хоногийн усны хэрэглээ	хоногт шаардлагатай усны хэрэглээ	Жилд хэрэглэх усны хэрэглээ	Шаардлагатай ундаргын хэмжээ
Х.нэгж	Хүн	хоног	л	м ³ /хоног	м ³ /жил	л/с, хоног
Жилд	11	250	150	1.65	412.5	0.02

Тайлбар: Ус хэрэглээний нормыг БОНХАЖ-ын сайдын тушаалаар батлагдсан 2015.07.30-ны өдрийн А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормоор тооцов.

IV.5.1. Ундны ус, ахуйн хэрэглээ:

Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын Сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтад заасан “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм” – ын дагуу зөөврийн усаар хангагддаг гэр хорооллын 1 хүний усны хэрэглээний хоногийн дундаж норм нь 20 литр/хоног/хүн бөгөөд төслийн багийн 11 хүн жилийн 250 хоногт агуулах дээр ажиллана гэж тооцвол:

$150 \text{ хоног} * 11 \text{ хүн} * 150 \text{ литр ус} = 412500 \text{ литр буюу } 412.5 \text{ м}^3 \text{ ус хэрэглэнэ.}$

IV.5.2. Агуулахад чийгтэй цэвэрлэгээ хийх:

Сард 2 удаа, нэг удаагийн цэвэрлэгээгээр 40 литр ус хэрэглэнэ гэж тооцвол:

$16 * 40 \text{ литр} = 640 \text{ литр буюу ойролцоогоор } 0.64 \text{ м}^3 \text{ ус хэрэглэнэ.}$

IV.5.3. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын Сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтад заасан “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм” – ын дагуу түрээслэж буй объектын гадна талбайд суулгах 20 ширхэг модны (100-120 см өндөртэй суулгац) усалгааг тооцвол:

Суулгасны дараах тогооны усалгаа $20 \text{ суулгац} * 60 \text{ литр} = 1200 \text{ литр буюу } 1.2 \text{ м}^3 \text{ ус.}$

Жилд $16 \text{ удаа} * 20 \text{ суулгац} * 40 \text{ литр} = 12800 \text{ литр буюу } 12.8 \text{ м}^3 \text{ ус хэрэглэнэ.}$

Нийт: Жилд ойролцоогоор - 426 м^3 ($2.85 \text{ м}^3/\text{хон}$) ус хэрэглэнэ.

IV.6. Агуулахын тавигдах шаардлага

Агуулахын барилгад тавих шаардлага: Төсөл хэрэгжих талбайн газар дээр очиж агуулахын стандартад нийцэж байгаа эсэхийг шалгаж төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж ажилласны үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хурлаар хэлэлцүүлж байна.

Агуулахаар түрээсэлж буй барилга нь цутгамал бетонон суурьтай, хүчитгэсэн блок болон төмөр хийцлэлийн ханатай, бетонон шалтай, төмөр дэвэртэй, камержуулсан байна.

Байршлын хувьд MNS 6458:2014 стандартын шаардлагын дагуу суурьшлын бүс, усан сан бүхий газар, хүн амын усан хангамжийн тэжээгдлийн бүстэй тус тус давхцалгүй, үер усны аманд бус, зэргэлдээх барилга байгууламжаас 6м-ээс их зайд байрлаж байна.



Зураг №3. Зэргэлдээх барилга байгууламжаас бм-ээс их зайд байршлын зураг

Агуулахын шал

- ✓ Шал нь хотгор, гүдгэр, нүх, хэвгий хазайлтгүй тэгш байх ба хөдөлгөөнгүй халтирахааргүй гадаргуутай, химийн бодист тэсвэртэй материалаар хийгдсэн байна.
- ✓ агуулахын шал болон галны хананы холбоос нь асгарч алдагдсан бодис гадагш алдагдахаар нүх сүв , зай завсаргүй байна.

Хүснэгт №8. Бетоны химийн нэмэлт түүхий эд

Төрөл	Нэр	Зориулалт	Онцлог шинж чанар
Бетон зуурмагийн нэмэлт бэхжүүлэгч	Polisintonol 101	Усны орц багасгана. Хөдөлгөөнт чанарыг ихэсгэнэ.	Усны зарцуулалтыг 50% багасгана Бетоны бат бэхийг нэмнэ. Барьцалдах хугацааг удаашруулна.
Бетон зуурмагийн нэмэлт бэхжүүлэгч	Polisintonol 201	Усны орц багасгана. Хөдөлгөөнт чанарыг ихэсгэнэ	Усны зарцуулалтыг 40% багасгана Бетоны бат бэхийг нэмнэ. Барьцалдах хугацааг удаашруулна
Бетон зуурмагийн нэмэлт бэхжүүлэгч	FLUX F5	Ус нэвтрүүлэх чанарыг багасгана. Хүйтэнд тэсвэртэй	Усны зарцуулалтыг 20-25% багасгана Бетоны бат бэхийг нэмнэ. Хөдөлгөөнт чанарыг нэмнэ
Бетон зуурмагийн уян налархай чанарыг дээшлүүлэгч	Flux F5 тип3 SLOW3	Бетоны бат бэх хүйтэнд тэсвэрлэлт ус нэвтрүүлэхгүй байдлыг дээшлүүлнэ.	Ус цементийн харьцааг 20-25% багасгана
Хөлдөлтийн эсрэг нэмэлт	ADDITIVA20	Бетоны шингэн фазын хөлдөх цэгийг бууруулах, хатууралтыг эрчимжүүлэх	-25 градус хүртэл температурт бетоны батжилтыг хангана
Бетон зуурмагийн нэмэлт	FLUX F11	Бетоны хольцын хөдөлгөөн	Тогтворжуулах үйлчилгээтэй

бэхжүүлэгч		хадгалах хугацааг нэмэгдүүлнэ.	
Олон үйлчилгээтэй хөдөлтийн эсрэг нэмэлт	Polifrom PM	Усны эсэргүүцлийг нэмэгдүүлнэ. Хүйтэнд тэсвэртэй	Усны эсэргүүцлийг сайжруулна. -25 градус хүртэл хүйтэнд тэсвэртэй
Олон үйлдэлт хувиргагч	Polifrom P5	Бетоны насжилтыг уртасгана.	Ус нэвтрүүлэх чанарыг багасгана. Хүйтэнд дэсвэртэй
Бетон зуурмагийн нэмэлт бэхжүүлэгч	Solitard S1	Ус нэвтрүүлэх чанарыг багасгана. Хүйтэнд дэсвэртэй	Ус нэвтрүүлэх чанарыг багасгана. Хүйтэнд дэсвэртэй
Бетон зуурмагийн нэмэлт бэхжүүлэгч	Polisintonol Uf11	Усны орц багасгана. Хөдөлгөөнт чанарыг ихэсгэнэ	Усны зарцуулалтыг 40% багасгана. Бетоны бат бэхийг нэмнэ. Барьцалдах хугацааг удаашруулна

Давуу талууд нь

- ✓ Ус цементийн харьцааг 50 хувь хүртэл бууруулна (нэмэгдэлгүй бетоны хувьд)
- ✓ Цементийн орцыг 30-40 хувь хүртэл багасгаж, тогтворжуулах нөлөөтэй.
- ✓ Хүйтэнд тэсвэрт чадвар, сульфатын эсэргүүцлийг мэдэгдэхүйц нэмэгдүүлнэ.
- ✓ Хамгийн бага Ус/цемент харьцааны үед бетон зуурмагийн хөдөлгөөнт чанарыг П1-ээс П5 болтол ихэсгэдэг.
- ✓ Хөдөлгөөнт чанарыг 4 цаг хүртэл хадгална.
- ✓ Ямар ч төрлийн цементийн идэвхитэй байдлыг нэмэгдүүлж, бат бэх чанарыг өндөр өсөлтийг хангана.
- ✓ Хүргэлтийн хэлбэр 1тн тусгай битүүмжлэл бүхий савтай.

Бүтээгдэхүүний аюулгүй ажиллагааны заавар

- ✓ Тус бодисууд нь шүлтгүй шингэн, хоргүй, зэврэлт явагддаггүй, хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэдэггүй.
- ✓ Уг бүтээгдэхүүнд борооны ус дусаал хог орох, ууршиж хатахаас сэргийлж таглаатай саванд хадгалах шаардлагатай.

Агуулахын барилгад тавих шаардлага: Төсөл хэрэгжих талбайн газар дээр очиж агуулахын стандартад нийцэж байгаа эсэхийг шалгаж төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж ажилласны үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хурлаар хэлэлцүүлж байна.

ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨМЖ, ШИЙДЭЛ

Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Химийн бодисыг захиалагчид тээвэрлэн хүргэж өгөхдөө бүхээгтэй битүү тэвштэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх
- ✓ Агуулахын ойр орчимд мод сөөг тарих, ургамалжуулах чийгтэй байлгах
- ✓ Химийн бодисыг тээвэрлэхдээ агаарт тоосжилт үүсгэхгүйн тулд хатуу хучилттай замаар тээвэрлэлт хийх
- ✓ Жил бүр агаарын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
- ✓ Машин, механизмуудаас агаарт тархах бохирдлыг багасгахын тулд засвар үйлчилгээг тогтмол хийх,
- ✓ Автомашины шатах тослох материалын бохирдлоос сэргийлэх
- ✓ Тээвэрлэлтийн автомашинд утааны шүүлтүүрийг тавих, мөн янданд оч баригч суурилуулах

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Хөрсний сорьц, дээж авч, мониторингийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх
- ✓ Төслийн хүрээнд ашиглаж буй машин механизм, зорчих хэсгүүдийг зөв, оновчтой төлөвлөх
- ✓ Ил задгай хог хаягдал хаяж хөрсийг бохирдуулахгүй байх
- ✓ Хатуу хог хаягдал түр хадгалах байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангах хөрсөнд аливаа бохирдол нэвчихгүй байхаар төлөвлөх
- ✓ Химийн бодисын алдагдлыг байнга хянах, хөрсөнд алдагдсан тохиолдолд нэн даруй цэвэрлэх
- ✓ Тээвэрлэлт хадгалалт, ашиглалтын үйл ажиллагааны хүрээнд химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- ✓ Химийн бодисын агуулах нь химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материал, хуурай элс, тогтворжуулагч, хамгаалах хэрэгсэл, хогийн шүүр, хориглох тууз гэх мэтээр хангагдсан байх
- ✓ Химийн бодисуудыг тээвэрлэх, ачих буулгах үедээ сав, баглаа боодлыг задрахаас сэргийлэх

Ургамлан нөмрөгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Төслийн талбай болон бусад талбайн ургамлыг хамгаалахын тулд тогтсон нэг маршрутын дагуу явах
- ✓ Машин механизм, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зориулалтын талбай гарган тухайн орчны ургамлын талхлагдахаас сэргийлэх
- ✓ Хог хаягдлыг тогтсон нэг цэгт байршуулах
- ✓ Химийн бодисыг ачиж, буулгах явцад хөрс, ургамлан бүрхэвч дээр химийн бодис асгахгүй байх

Амьтны аймагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Хөрсийг янз бүрийн химийн бодисоор болон ахуйн хэрэглээнээс гарсан хог хаягдлаар бохирдуулахгүй байх

- ✓ Хөрсний микро биологийн шинжилгээ хийлгэх, түүнд тулгуурлан авч болох арга хэмжээг хэрэгжүүлэх
- ✓ Хөрсөн орчны бохирдол ихэссэнээр хөрсний бичил биетнүүд багасах ба үүнээс сэргийлж ариутгал хийх
- ✓ Агуулах дотор хортон шавж орох, мэрэгчид үүрлэж үүрээ засахаас сэргийлж, түүнийг устгах, ариутгах ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авах

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээ

- ✓ Агуулахад түр хадгалагдаж байгаа бодисын сав баглааны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж байх ёстой. Агуулахад хадгалагдаж байгаа бодисын үерийн үед алдагдах нэг гол шалтгаан нь сав, баглааны битүүмжлэлийн асуудал байдаг.
- ✓ Хур борооны усыг хуримтлуулан ногоон байгууламжийн усалгаанд ашиглах.
- ✓ Унд ахуйн усыг стандартын шаардлага хангасан нөөц саванд хадгалах

Үерийн улмаас химийн бодис алдагдахаас сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- ✓ Агуулах руу үерийн ус орохоос сэргийлж суваг, далан татах
- ✓ Агуулахад хурын ус зайлуулагч хоолой нэмэлтээр суулгах

Нийгэм эдийн засагт үзүүлэх үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Уг төслийн хүрээнд нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага юм. Харин агуулахад ажилладаг ажилчдад үзүүлж болох сөрөг нөлөөллийг бууруулах, үүнээс гадна ажилчдын ХАБЭА-ны дүрмийг баримтлан ажиллах шаардлагатай юм. Үүнд:

- ✓ Төслөөс дотоодын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж, төсөлд бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
- ✓ Хөдөлмөр, хамгааллын аюулгүй ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журмыг дагаж мөрдөх
- ✓ Шаардлагатай газруудад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар анхааруулга, санамж, зурагт хуудас хийж байрлуулах;
- ✓ Ажиллагсдыг мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлж, улирал тутам шинжилгээнд хамруулах
- ✓ Цахилгаан багаж хэрэгсэлтэй хэрхэн харьцаж ажиллах талаар ажиллагсдыг сургалтад тогтмол хамруулж, осол гэмтлийн бүртгэл хөтлөх, аюул ослоос сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх
- ✓ Болзошгүй аюул осол тохиолдоход яаралтай мэдэгдэж, тухайн үед нь саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээг авах

Аюулгүй ажиллагааны үндсэн шаардлагууд

- ✓ Үйлдвэрлэлийн процесс, машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг хангасан байх
- ✓ Цахилгаан тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан байх, цахилгааны ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байх
- ✓ Ажлын тусгай хувцасны чанарын үзүүлэлтийн жагсаалтыг харгалзах стандартыг баримтлан эдэлгээний хугацааг тогтоож байх
- ✓ Галын аюулгүй байдлыг хангах, дотоод дүрмийг сахих, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгах, тэдгээрийг ажиллагсдад ашиглуулж сургах

Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх зөвлөмж

Төслийн хэвийн үйл ажиллагааг хангахдаа байгаль орчин, хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор дараах ажилуудыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

- ✓ Ажлын байранд гал гаргахыг хатуу хориглосон анхааруулга тэмдгийг үзэгдэхүйц газар байрлуулах
- ✓ Байгаль орчныг хамгаалах чиглэл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаагаар ажилчдын дунд сургалт зохион байгуулах, сургалтан хамрагдаагүй хүнийг ажилуулахгүй байх
- ✓ Агуулахын эмнэлгийн анхан шатны тусламжийн өрөөнд болзошгүй аваар, ослын үед хэрэглэх, өвчин намдаах эм, ариутгасан спирт, цэвэр боолт, хүчил, шүлт саармагжуулах бодис, цэвэр ус зэргийг бэлэн байлгах
- ✓ Гал түймэр, үер усны аюул зэрэг аюул ослын үед авах арга хэмжээний онцгой байдлын хэлтсийн мэргэжилтнээс тусламж авч, зөвлөмжийг боловсруулан батлах ба зөвлөмжийн дагуу сургуулилтг тодорхой хугацаанд хийж хэвших
- ✓ Аюул осол болсон үед цугларах цэгийг хашааны хаалганы хойд талд, харуулын хажууд тодорхойлж, тэмдэглэгээ байршуулах, ажиллагсдад мэдээлэх,
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, химийн бодистой харьцах зааварчилгааг ажиллагсдад танилцуулж, мэдлэгийг шалгасан шалгалт тестийг авч, ажлын үнэлгээнд оруулах,
- ✓ Ажиллагсдад галын аюулаас урьдчилан сэргийлэх зааврыг өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалтыг төлөвлөн сургуулилт хийх, гал унтраах хэрэгслийг ашиглаж сургах,
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан агаар, ус, хөрсний мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх,
- ✓ Жил бүр БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг гаргаж, БОАЖЯ-аар батлуулах шаардлагатай.

Бодис хадгалахад баримтлах зөвлөмж

- ✓ Химийн бодис хадгалах өрөө нь гадны хүн үл нэвтрэх хаалт, цоожтой байх ба бодис хадгалах агуулах нь зөвхөн хариуцагч этгээдийн хувийн тэмдэг бүхий лацаар битүүмжлэгдсэн байна.
- ✓ Лац битүүмжийг байнга шалгаж байх.
- ✓ Агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна.

Ногоон байгууламж байгуулах зөвлөмж

VI.6.1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мо тарьж ургуулах тухай

Монгол улсын ерөнхийлөгч НҮБ-ийн ерөнхий Ассемблейн 76-р чуулган дээр байгаль орчны доройтол, цөлжилт, шар шороон шуургатай тэмцэх зорилгоор Монгол улс 2030 он гэхэд нэг тэрбум мод тарьж ургуулахаа зарласан. Мод тарьж ургуулах нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хөрсний биотопыг сэргээх, органик нэгдлийг хөрсөнд бий болгох зэрэг ач холбогдолтой. Төслийн үйл ажиллагаанд тогтмол 11 хүний ажлын байраар хангадаг тул нэг ажилчин жил бүр хавар, намартаа 2 мод тарих бүрэн боломжтой байна.

“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн 7.2.4-д аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн эзэмшлийн газрын 10-аас доошгүй хувьд мод, зүлэг тарина гэж заасан байдаг. “Бэлдэвжих” ХХК нь түрээсийн агулахад үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байгаа учир Нийслэлийн байгаль орчны газартай хамтран өөр байршилд мод тарьж ургуулах боломжтой. **Тухайлбал: MNS 5918:2023 стандартын дагуу хус, улиас, улиангар, шинэс, нарс, хайлаас, гацуур г.м**

“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийн дагуу төсөл хэрэгжүүлэгч нь талбайн 10%-иас доошгүй талбайд мод тарьж, зүлэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Ногоон байгууламж байгуулснаар дараах олон талын ач холбогдолтой байна. Үүнд:

- ✓ Үйлдвэрийн орчинд бичил уур амьсгалыг бүрдүүлэх, уур амьсгалыг зөөлрүүлэх;
- ✓ Тоос, шороо, автомашины хөө, тоос тортгийг багасгаж агаарын бохирдлыг бууруулах, шингээх, Орчны дуу чимээг намдаах
- ✓ Ажиллах таатай орчин бий болгох;
- ✓ Агаар цэвэршүүлэх, хүчилтөрөгчийг ялгаруулах.

Татан авалтын тээвэрлэлтэд тавигдах шаардлага: ОХУ-ын Новосибирскээс автотээвэрээр татан авалтаа жилд 5 удаа, 20тн/1удаа/сар давтамжтайгаар химийн бодисийн тээвэр ложистикийн эрх болон туршлага бүхий компаниар тээвэрлүүлэн авна. Монложистик ХХК-тай аман хэлэлцээр хийсэн.

Түгээлтийн тээвэрлэлтэд тавигдах шаардлага: УБ хот дахь бетон зуурмагийн үйлдвэрүүдийн бөөгнөрөл баруун бүсэд, хотын захад төвлөрдөг бөгөөд төсөл төлөвлөсөн хүчин чадлаар ажиллахдаа 2-3 бетон зуурмагийн үйлдвэрийн хэрэгцээг хангана. Хотын хүн амын нягтаршил өндөр- суурьшлын бүсэд түгээлт хийхгүй. Түгээлтийн хувьд компани өөрийн эзэмшлийн Porter машинаар түгээтийг хийнэ.

Агуулахын барилгад тавих шаардлага: Төсөл хэрэгжих талбайн газар дээр очиж агуулахын стандартад нийцэж байгаа эсэхийг шалгаж төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж ажилласны үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хурлаар хэлэлцүүлж байна. Агуулахаар түрээсэлж буй барилга нь цутгамал бетонон суурьтай, хүчитгэсэн блок болон төмөр хийцлэлийн ханатай, бетонон шалтай, төмөр дээвэртэй, камержуулсан байна.

Байршлын хувьд MNS 6458:2014 стандартын шаардлагын дагуу суурьшлын бүс, усан сан бүхий газар, хүн амын усан хангамжийн тэжээгдлийн бүстэй тус тус давхцалгүй, үер усны аманд бус, зэргэлдээх барилга байгууламжаас бм-ээс их зайд байрлаж байна.

2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

“Бэлдэвжих” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Химийн бодис хадгалах, импортлох, худалдаалах” төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ундны усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээ,
- ✓ Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих, хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож, доор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэх.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан. Хуулийн дээрх шаардлагын дагуу химийн бодис хадгалах, худалдаалах, импортлох төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалх арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Зардал, 2024 он /төгрөг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ажилтнууд химийн бодисонд түлэгдэх, амьсгал боогдох, хурц хордлого үүсгэх	Бодисын хаягдлыг зөвшөөрөлтэй газраар, эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй аргаар холбогдох комиссыг байлцуулан устгаж, акт үйлдэх	300.000	MNS 0017-2-3-16:1988. Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам. - MNS 3384-1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага. -MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS0017-2-5-11:1988. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2		Химийн хорт болон аюултай бодис хадгалах складыг зохих журмын дагуу ашиглаж, тогтмол хараа хяналттай, цоожтой байлгаж, хаалгыг лацдах	200.000	
3		Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулах		
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах	Аюулыг мэдээлэх хуудас ашиглах, тайлагнах		
Нийт			500,000	

Хүснэгт

4. ТЭРБУМ МОД ТӨСЛИЙН ХҮРЭЭНД

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих төслийн хүрээнд 20 ш мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийнэ.

№	ТАРИХ МОД БУТНЫ ТӨРӨЛ ЗҮЙЛ	НИЙТ
1	Бургас, Шар хуайс, Үхрийн нүд,	20 ш
	Төсөвт өртөг	500.000

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ордын ойр орчмын бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

төслийн талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй.

“Бэлдэвжих” ХХК-ийн биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон үйлдвэр орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Бэлдэвжих" ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагаагаар ажиллах шаардлагатай

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Эдгээрт:

Үйлдвэрлэлийн хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулж, хогийг ангилан ялгаж дахин ашиглах хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

Дахин ашиглагдах боломжтой хог хаягдлын ангилан ялгалтын хувь хэмжээг нэмэгдүүлж, Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бий болсон дахин ашиглагдах хог хаягдлыг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг бий болгоно.

9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Бэлдэвжих" ХХК -ийн Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт №4. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Ажилчид	Үйл ажиллагааны зардлаар	Жилд 1 удаа
2	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр хангах	Ажилчид	ХАБЭА-ын зардлаар	Жилд 1 удаа
3	БОМТ-ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч байх	Төслийн удирдлага	-	Жил бүр
4	Жил бүрийн БОМТ-г БОАЖЯ-аар хянуулан баталгаажуулах	Байгаль орчны мэргэжилтэн	-	Жил бүр

10. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨ

"Бэлдэвжих" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт №18. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Төв аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2024 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Үйлдвэрт
	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Уулзалт			БОАЖЯ-ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2024 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	Засаг даргын тамгын газарт

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Үйлдвэрлэлийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд,

шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана. "Бэлдэвжих" ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай

Хүснэгт №5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналтын хугацаа, давтамж	Зардал, 2024 он /төгрөг/	Баримтлах стандарт, аргачлал
УСАН ОРЧИН					
1	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO3), Ca, Mg, Na, K, SO4, NO2, NO3, NH4, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Унд ахуйн ус	Жилд 2 удаа	92.000	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт.
2	Хаягдал ус	Сав баглаа боодлыг угаах бүрт шинжилгээ хийлгүүлэх	Жилд 1 удаа	125,000	
ХӨРСӨН БҮРХЭВЧ					
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO3, P2O5, K2O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайд хог хаягдлын цэг 47° 53.217'N 106° 38.128'E 2.Химийн бодис ачиж буулгах талбайн орчмоос 47° 53.201'N 106° 38.103'E	Жилд 2 удаа	100.000	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга
НИЙТ ДҮН				317,000 ТӨГРӨГ	

12. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ НИЙТ ЗАРДАЛ

“Бэлдэвжих” ХХК-ийн 2024 оны БОМТ-г БОНХЯ-ны Сайдын 2014 оны 1 сарын 06-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2024 онд БОМТ-нд нийт 1,3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт №20. 2024 оны БОМТ-ний нийт зардал

№	Арга хэмжээ	Зардал, 2024 он /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	500.000
2	Тэрбум мод төслийн хүрээнд	500.000
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	317,000
Нийт дүн		1,317.000